



# УЛСЫН ТООЛЛОГО-2010

## ХҮН АМ, ОРОН СУУЦНЫ 2010 ОНЫ ЭЭЛЖИТ ТООЛЛОГО

2010 оны 4 дүгээр сарын 30

Дугаар № 1



### ЭРХЭМ УНШИГЧ ТАНАА

*Эрхэм уншигч та бүхэнтэй Хүн ам, орон сууцны 2010 оны ээлжит тооллогын асуудлаар шуурхай мэдээлэл хүргэх “Улсын тооллого-2010” хэмээх мэдээллийн хуудсаараа тогтмол уулзах болсондоо таатай байна. Эдүгээ дэлхийн бусад улс орнууд бидний нэгэн адил тооллого явуулах бэлтгэлээ базааж байгаа бөгөөд 2010 онд 67 орон тоолох үйл ажиллагааг зохион байгуулна. Арван жил тутамд улс орон даяар зохион байгуулагддаг ээлжит тооллогыг амжилттай явуулах нь Нэгдсэн Үндэстний Байгууллага, гишүүн орнуудын өмнө Монгол Улс хуулийн дагуу хүлээсэн үүрэг бөгөөд бидний бэлтгэж байгаа мэдээлэл энэхүү зорилгыг хангахад чухал ач холбогдолтой болно гэдэгт эргэлзэхгүй байна. Энэхүү хүндтэй бөгөөд хариуцлагатай үүргийг та бид хамтран хэрэгжүүлэхийн төлөө бүх талаар хамтарч ажиллах учиртайг тэмдэглэхийн сацуу товхимлын анхны дугаар гарч буй өдрөөс хойш Монгол Улсын хүн ам, орон сууцны тоолох үйл ажиллагаа эхлэхэд 194 хоног үлдээд байгааг найрсгаар сануулж байна.*

*Та бүхнийг хүндэтгэсэн.*

*ҮСХ-ны дарга,  
С.Мэндсайхан*

2010 оны 4 дүгээр сарын 30

## ХҮН АМ, ОРОН СУУЦНЫ УЛСЫН ТООЛЛОГО 2010 ОНЫ 11-Р САРЫН 11-НЭЭС 17-НЫ ӨДРҮҮДЭД ЯВАГДАНА.

### Тооллого гэж юу вэ?

Хүн ам, орон сууцны улсын тооллого гэдэг нь Засгийн Газраас тогтоосон хугацаанд Монгол Улсын нутаг дэвсгэр дээр оршин амьдарч буй нийт хүн амыг хамарч хүн ам зүй, эдийн засаг, нийгмийн хүрээний мэдээллийг цуглуулах, нэгтгэх, боловсруулах, үр дүнг хэвлэн нийтлэх цогц үйл ажиллагаа юм.

Монгол Улс нь зах зээлийн эдийн засгийн тогтолцоонд шилжин 20 гаруй жилийн нүүрийг үзэж байгаа бөгөөд энэхүү хугацаанд хүн амын өсөлт хөгжил, шилжилт хөдөлгөөн, бичиг үсгийн боловсрол, орон сууцны нөхцөл, хангамжийн талаарх мэдээллийг гаргах зайлшгүй нөхцөл бүрэлдсэн болно.

Хүн ам, орон сууцны улсын тооллогоос хүн амын тоо, түүний тархан суурьшилт, хүн ам зүйн үзүүлэлтүүд, ястан үндэстэн, боловсрол, бичиг үсгийн мэдлэг, шилжих хөдөлгөөн, хотжилт, ажил эрхлэлт, өрхийн үзүүлэлт зэрэг олон тооны үзүүлэлтүүд гардаг бөгөөд эдгээр үзүүлэлтүүд дээр тулгуурлан дараагийн 10 жил хүртэлх судалгаануудыг гаргах боломжтой юм.

Дэлхийн олон орны хүн амын тооллогын түүхээс авч үзэхэд хүн амын тоо, өсөлт хөгжил, нөхөн үржихүй, амьдрах орчны талаарх өргөн хүрээтэй магадлал сайтай мэдээллийг гагцхүү хүн амын тооллого олгодог болох нь тогтоогдсон байдаг.



### Хүн ам, орон сууцны

#### 2010 оны улсын тооллогын зорилго, ач холбогдол

Сүүлийн 10 жилийн хугацаанд хүн ам зүй, эдийн засаг, нийгмийн байдалд гарсан өөрчлөлт, шалтгаан, нөхцөлийг судлах, ирээдүйн хүн ам зүй, эдийн засаг, нийгмийн хөгжлийг төлөвлөх, бодлого, хөтөлбөрийг боловсруулах, эрдэм шинжилгээний ажил, судалгаанд шаардлагатай статистикийн тулгуур мэдээлэл бүрдүүлэхэд оршино. Монгол Улсын хүн амын тоо, нас, хүйсийн бүтэц, боловсрол, ажил эрхлэлт, эдийн засгийн үйл ажиллагааны талаар цогц мэдээллийг бүрдүүлснээр улс орны өнгөрсөн хугацааны хөгжлийг үнэлэх, ирээдүйн чиг хандлагыг тодорхойлох бололцоотой болох бөгөөд Засгийн Газраас хэрэгжүүлж буй ажилгүйдэл, ядуурлыг бууруулах, хүн амын өсөлт, хөгжлийг хангах, хүн амын ахуйн нөхцөлийг сайжруулах, орон сууцжуулахад чиглэсэн бодлого боловсруулж, хэрэгжүүлэхэд чухал ач холбогдолтой.

### Тооллого явуулах хууль эрх зүйн үндэс

Хүн ам, орон сууцны 2010 оны улсын тооллогыг дараах хууль, эрх зүйн зохицуулалтын хүрээнд зохион байгуулж явуулна. Үүнд:

“Статистикийн тухай” хуулийн 7 дугаар зүйлийн 1 дэх хэсэг;

“Хүн ам, орон сууцны улсын тооллогын тухай” хууль;

Улсын Их Хурлын 2008 оны 2 дугаар сарын 6-ны өдрийн Улсын комисс байгуулах тухай 19 тоот тогтоол;

Хүн ам, орон сууцны тооллогын бэлтгэл ажлыг хангах талаар Улсын комиссын ажлын төлөвлөгөө;

Монгол Улсын Хүн ам, орон сууцны тооллогын улсын комиссын 2009 оны 5 дугаар сарын 29-ний өдрийн Тооллогын комисс байгуулж ажиллуулах тухай 02 тоот тогтоол;

Үндэсний статистикийн хорооны даргын 2008 оны 10 дугаар сарын 31-ний өдрийн Хүн ам, орон сууцны 2010 оны тооллогын Мастер төлөвлөгөө батлах тухай 01/139 тоот тушаал;

Үндэсний статистикийн хорооны даргын 2009 оны 10 дугаар сарын 21-ний өдрийн Хүн ам, орон сууцны тооллого зохион байгуулж явуулах нэгдсэн удирдамжийг батлах тухай 01/135 тоот тушаал;

Үндэсний статистикийн хорооны даргын 2009 оны 10 дугаар сарын 21-ний өдрийн Хүн ам, орон сууцны тооллогын асуулга, нэгтгэлийн маягт, тэдгээрийг нөхөх зааврыг батлах тухай 01/135 тоот тушаал;

Улсын Их Хурлын 2009 оны 12 дугаар сарын 9-ний өдрийн Тооллогын тов тогтоох тухай 88 тоот тогтоол;

### Тооллогын тов

Монгол Улсын Засгийн Газар “Статистикийн тухай”, “Хүн ам, орон сууцны улсын тооллогын тухай” хууль, УИХ-ын 2008 оны 18 тоот тогтоолын дагуу хүн ам, орон сууцаа 2010 оны 1 дүгээр сарын 9-өөс 10-нд шилжих шөнийн 00 цагаар тов тогтоож, 10-аас эхлэн нэлэнхүй аргаар тоолох гэж байсан боловч хэд хэдэн шалтгааны улмаас тооллогын товыг өөрчлөх шаардлага гарсан.

1. Томуугийн А хүрээний (H1N1) шинэ вирус халдвар
2. Байгаль, цаг уурын хүндрэл
3. Иргэний бүртгэл, мэдээллийн хангалтгүй байдал

Эдгээр шалтгааны улмаас Монгол Улсын Их Хурлын 2009 оны 12 сарын 09-ний өдрийн 88-р тогтоолоор Хүн ам, орон сууцны улсын ээлжит тооллогын товыг 2010 оны 11 дүгээр сарын 10-наас 11-нд шилжих шөнийн “00” “тэг тэг” цагаар өөрчлөн тогтоосон.

### Цаг үеийн мэдээлэл

Хүн ам, орон сууцны 2010 оны улсын тооллогын мэдээллийг нийт хүн амд хүргэх, сурталчлах [www.toollogo2010.mn](http://www.toollogo2010.mn) цахим хуудас 2010 оны 4 дүгээр сарын 12-ны өдрөөс шинэчлэгдэн гарлаа. Энэхүү хуудаснаас та бүхэн тооллоготой холбоотой бүхий л мэдээ, мэдээлэл, тооллого явуулах хууль, эрх зүйн үндэс, Монгол Улсын хүн амын тооллогын түүх, тооллогын ерөнхий



### Хүн ам, орон сууцны тооллогын хуулиас...

#### 17 дугаар зүйл. Тооллого зохион байгуулж явуулахад иргэдийн хүлээх үүрэг

17.1. Тооллогод иргэд дор дурдсан үүрэгтэй оролцоно:

17.1.1. Тооллогын асуулгад үнэн зөв, бүрэн хариулт өгөх;

17.1.2. Тооллогын ажилтныг байр, орон сууцандаа нэвтрүүлэх;

17.1.3. Тооллогод хамрагдсан тухай баримт бичиг тооллогын ажилтнаас авах.

#### 18 дугаар зүйл. Тооллогын мэдээллийн нууцлал, хадгалалт, хамгаалал

18.3 Үндэсний статистикийн

хорооноос нийтэд ашиглуулах зорилгоор албан ёсоор боловсруулан нэгтгэсэнээс бусад хэлбэрээр хувь хүний холбогдолтой тооллогын мэдээллийг бусад ашиглуулах, задруулахыг хориглоно.

#### 4 дүгээр зүйл. Тооллого зохион байгуулж явуулах арга

4.1. Тооллого зохион байгуулж явуулахад дараах аргыг ашиглана:

4.1.1. тооллогын хугацаанд хүн амыг нэг бүрчлэн тоолох уламжлалт арга;

4.1.2. хүн амын регистрийн бүртгэлд суурилсан бүртгэлийн арга;

4.1.3. түүвэр судалгааны арга.

#### 5 дугаар зүйл. Тооллого явуулах зарчим

5.1. Тооллогыг дараах зарчмаар явуулна:

5.1.1. хүн бүрийг нэг бүрчлэн тоолох;

5.1.2. тооллогын хугацаанд тооллогод хамрагдах нутаг дэвсгэрт нэгэн зэрэг тоолох;

5.1.3. тооллогын мэдээлэл нийтлэг, иж бүрэн байх;

5.1.4. тооллогыг тогтмол, давтамжтай явуулах.



ойлголтууд, тооллого явагдсан он, түүнчлэн орон нутгийн хүн ам зүйн болон бусад үзүүлэлт, дэлхийн бусад орнуудын тооллогын талаарх мэдээ, мэдээллийг авах боломжтой боллоо.

### Дэлхийн хөтөлбөр

**Зорилго:**

Гишүүн орнуудыг хүн ам, орон сууцны тооллогоо 2005-2014 онуудад наад зах нь нэг удаа зохион байгуулж, үр дүнгээ тархахад нь дэмжлэг үзүүлэх.


**Үйл ажиллагааны чиглэл:**

- Тооллогын арга зүйн гарын авлагуудыг боловсруулж, шинэчлэх
- Улс орнуудад туршлагаа хуваалцах үйл ажиллагааг нь хөнгөвчлөх
- Тооллого зохион байгуулахтай холбоотойгоор ҮСХ-ны чадавхийг нэмэгдүүлэх

### Гишүүн орнуудын үйл ажиллагаа



### Гишүүн орнуудын үйл ажиллагаа



2010 оны 4 дүгээр сарын 15-ны байдлаар Дэлхийн **1 453 442 368** тэрбум хүн тоологдоод байна.

### Сонирхолтой статистик

- Манай эриний өмнөх 10000 онд дэлхийд 5 сая орчим хүн байсан бол манай эриний өмнөх 8000 онд 8 сая болсон байна. Харин манай эриний 1900-аад оны үед дэлхий дээр 1.6 тэрбум хүн байсан бол өнөөгийн байдлаар дэлхий дээр 6.8 тэрбум орчим хүн амьдарч байна.
- Монгол Улсын 1 сая дахь иргэн 1962 оны 2 сард төрсөн бол 2 сая дахь иргэн 1988 оны 7 дугаар сарын 11-нд төрсөн байна. Харин нийслэл Улаанбаатар хотын 1 сая дахь иргэн 2007 оны 4 сард мэндэлжээ.
- Хүн амьдралынхаа туршид 370 мянган куб метр агаараар амьсгалдаг.
- Дэлхийн хуурай газрын гуравны нэг болох цөлийн нутаг дэвсгэрт дэлхийн хүн амын 13 хувь нь амьдарч байна. Дэлхийн хүн амын 85 хувь нь Экваторын бүсээс хойших газар нутагт амьдардаг.

### Ойрын хугацаанд

Хүн ам, орон сууцны 2010 оны улсын тооллогын бэлтгэл ажлын хүрээнд аймаг, нийслэл, сумдын тооллогын комиссын дарга нарт тооллогын зохион байгуулалтын талаар мэдээлэл өгөх сургалтыг бүх аймаг, нийслэлд хийхээр төлөвлөж байна. Сургалтаар анхан шатны нэгжид Хүн ам, орон сууцны 2010 оны улсын тооллогын бэлтгэлийг хангах ажлын хүрээнд иргэний бүртгэл, хөдөлгөөнийг бүрэн хөтөлж, бичиг баримтын зөрчлийг арилгах, хаягжилт, дугаарлалтыг цэгцэлж сайжруулах, хүн амыг тооллогод идэвхтэй оролцуулах, үнэн бодит мэдээлэл өгөх итгэл, үнэмшлийг бий болгох, тооллогын ач холбогдлыг ухуулан таниулахад чиглэсэн сурталчилгаа хийх зэрэг засаг захиргааны нэгжийн зүгээс хариуцаж хийх ажлуудыг эрчимжүүлэх юм. Түүнчлэн зохион байгуулалттай холбоотой асуудал болох тоологч, шалгагчаар ажиллах иргэдийг эртнээс судалж бүрдүүлэхэд одооноос анхаарч ажиллах шаардлагатай байгааг мэдээлж, хэлэлцүүлэг явуулж цаашид анхаарах асуудлаар санал, дүгнэлт гаргана.

### Хүн ам, орон сууцны тооллогын үе шат

Хүн ам, орон сууцны 2010 оны ээлжит тооллого нь дараах үндсэн үе шаттай байна. Үүнд:

I	Тооллогын бэлтгэлийг хангах үе /2008 оны 6 сараас 2010 оны 10 сар/
II	Тоолох үе /2010 оны 11 сар/
III	Тооллогын мэдээлэл боловсруулах үе /2010 оны 11 сараас 2011 оны 9 сар/
IV	Тооллогын хяналт, үнэлгээ хийх үе /2011 оны 8 сараас 2012 оны 3 сар/
V	Тооллогын үр дүнд дүн шинжилгээ хийх үе /2011 оны 7 сараас 2013 он/
VI	Тооллогын мэдээллийн сан үүсгэх, үр дүнг тархах үе /2011 оны 7 сараас 2013 он/

## МОНГОЛ УЛСЫН ХҮН АМЫН ТООЛЛОГЫН ТҮҮХ

XX зуунд Монгол Улс хүн амаа 9-н удаа тоолжээ.

<b>2000 он</b>	Монгол Улсын хүн ам, орон сууцны 2000 оны улсын тооллого нь төлөвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгаас зах зээлийн эдийн засгийн харилцаанд шилжих шилжилтийн үед хийгдсэн анхны тооллого юм.	<b>2373.5 мян.хүн</b>	
<b>1989 он</b>	Эдийн засгийн харилцан туслалцах зөвлөлийн аргачлалын дагуу 1969, 1979, 1989 оны тооллогыг явуулсан.	<b>2044.0 мян.хүн</b>	1979 онд хотын хүн амын тоо, хөдөөгийн хүн амаас их буюу 51.5-ийг хувийг эзлэх болсон.
<b>1979 он</b>	НҮБ-ын зөвлөмжийн дагуу эдгээр тооллогыг 10 жилд нэг удаа явуулдаг болсон	<b>1595.0 мян.хүн</b>	Хүн амын жилийн дундаж өсөлт 2.9 буюу хамгийн өндөр байсан жилүүд
<b>1969 он</b>	Хүн амаа тоолохоос гадна орон сууцны фондыг анх удаа хамт тоолсон.	<b>1197.6 мян.хүн</b>	Хүн ам зүйн ачаалал буюу 15-64 насны 100 хүнд оногдох хүүхэд, өндөр настны харьцаа 101.4 байсан.
<b>1963 он</b>	1963 оны тооллогод цахим тооцоолуур машиныг анх удаа ашигласан байна.	<b>1017.1 мян.хүн</b>	Нийт хүн амын 21.6 хувь нь хотод, 78.4 хувь нь хөдөө амьдарч байсан. Хүн амын тоог тэнцүү хувааж буй нас буюу голч нас нь 26.7
<b>1956 он</b>	Олон улсын аргачлалыг ашиглан явуулсан.	<b>845.5 мян.хүн</b>	
<b>1944 он</b>	Дайны жилүүдэд хийсэн тооллого	<b>754.2 мян.хүн</b>	Хүн амын жилийн дундаж өсөлт 0.3 буюу XX зууны хамгийн бага өсөлттэй жилүүд байсан.
<b>1935 он</b>	1921 оны Ардын хувьсгалын дараах анхны тооллого	<b>738.2 мян.хүн</b>	
<b>1918 он</b>	XX зууны анхны тооллого	<b>647.5 мян.хүн</b>	Түүвэр аргаар тоолсноос 542.5 мянга нь монгол, 100.0 мянга нь хятад, 5 мянга нь орос иргэд байсан. Нийт хүн амын 36.3 нь 18 хүртэлх, 40.5 нь 18-50 насны 23.2 хувь нь 51-ээс дээш насны хүн байлаа.

### ХҮН АМ, ОРОН СУУЦНЫ ТООЛЛОГОО ХАМТДАА ЯВУУЛЦГААЯ.

#### МАНАЙ ХАЯГ:

Хүн ам, орон сууцны тооллогын товчоо, Үндэсний Статистикийн Хороо.

Монгол Улс, Улаанбаатар-20 а,  
Бага тойруу-44, Засгийн Газрын III байр,  
Өрөө 507, 520.

Утас: 51-262325, 11-329940

Факс: 11-327885

И-мэйл: censusbureau@nso.mn

Вэб хаяг: www.toollogo2010.mn